



СОЁМБОМ ЭДЭЭ

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

№29 /243/

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2022.02.11



Монгол цэрэг энхийн үйлсэд

Түүхэнд энэ өдөр

1957 он.

МАХЦ-ын Төв Хорооны Улс төрийн Товчооны 57 дугаар тогтоолоор "Ардын цэрэгт туслах сайн дурын нийгэмлэгийг байгуулах тухай" шийдвэр гарчээ.

АФГАНИСТАН УЛСАД ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭСЭН ЦЭРГИЙН АЛБА ХААГЧДЫН ЭЭЛЖИТ ХЭЛЭЛЦҮҮЛГЭЭР...



Энхийг дэмжих ажиллагаанд оролцож эхэлсний 20 жилийн ойн хүрээнд Монгол Улсын Зэвсэгт хүчнээс "Исламын Бүгд Найрамдах Афганистан Улсад явагдсан "Афганистаны үндэсний армийг хөгжүүлэх хөтөлбөр", "Тогтвортой эрх чөлөө" олон улсын ажиллагаанд үүрэг гүйцэтгэсэн Артиллерийн сургалтын хөдөлгөөнт цэргийн багуудын туршлага, сургамж" сэдэвт хэлэлцүүлэг өнөөдөр Зэвсэгт хүчний 120 дугаар ангид үргэлжилж байна.

Тусуулзалт, хэлэлцүүлэгт ЗХЖШ-ын нэгдүгээр орлогч дарга бригадын генерал

С.Ганбямба, СБТГ-ын дарга бригадын генерал Д.Гандорж, хурандаа Д.Мөнхсайхан, С.Жавхлансүрэн, Д.Содномцог, бэлтгэл хурандаа Б.Хадбаатар, Р.Канад, хошууч Ц.Түвшинжаргал нар болон 22 ээлжийн цэргийн багийн удирдлага, бие бүрэлдэхүүний төлөөлөл оролцож, ажиллагааны өмнөх бэлтгэлийн онцлог, үүрэг гүйцэтгэсэн бие бүрэлдэхүүний судалгаа, ар тал, техникийн хангалтын байдал, сэтгэл зүйн бэлтгэлжилт, үүрэг гүйцэтгэж байх хугацааны талаарх туршлага сургамж, ажиллагаанд тулгарч байсан

хүндрэл бэрхшээл, тэдгээрийг даван туулсан туршлага зэрэг сэдвийн хүрээнд хэлэлцүүлэг өрнүүлэв. Энэхүү хэлэлцүүлэг цаашид Зэвсэгт хүчний 150, 120, 303, 032, 084, 027, 310, 311 дүгээр ангиуд болон Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэлийн байрлалд 2022 оны 4 дүгээр сар хүртэл үргэлжлэх юм.

Энэ дашрамд сонирхуулахад, 2003-2021 онд Афганистан Улсад явагдсан олон үндэстний цэргийн ажиллагаанд Монгол Улсын Зэвсэгт хүчнээс давхардсан тоогоор 7100 орчим цэргийн алба хаагч үүргээ нэр төртэй гүйцэтгэсэн бөгөөд сүүлчийн ээлжийн цэргийн багийн бие бүрэлдэхүүн өнгөрсөн оны тав,

зургаадугаар сардэхорондоо ирсэн билээ. Афганистан улсад Монголын Зэвсэгт хүчний цэргийн багууд үүрэг гүйцэтгэсэнээр даян дэлхийн энх амгалангийн үйл хэрэгт өөрийн хувь нэмрийг оруулсны зэрэгцээ монгол эх орон, монгол цэргийн нэр хүндийг өндөрт өргөж, мэргэжлийн ур чадвар, сахилга бат, зохион байгуулалтаараа олон үндэстний цэргийн алба хаагчдад үлгэр дуурайл болсоор ирснийг гадаад орнуудын төр, засгийн удирдлага, цэргийн мэргэжилтнүүд өндрөөр үнэлсэн юм.



МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

ВАКЦИНЖУУЛАЛТ I ТУН	ВАКЦИНЖУУЛАЛТ II ТУН	ДАРХЛАА СЭРГЭЭХ ТУН
2,270,250 /69.8%!	2,171,433 /66.7%!	1,012,558 31,0%

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН	ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ	ЭДГЭРСЭН
8090 +112	111	7862

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол	Нийт: 406,400,320
Эдгэрсэн	Нийт: 326,144,351
Нас барсан	Нийт: 5,808,895

Үс засуулбал:
Эрч хүч ихэснэ
НАРАН УРГАХ, ШИНГЭХ:
08.05-18.07
БАРИЛДЛАГА:
Үл тохирох
ШҮТЭН БАРИЛДЛАГА:
Төрөхүй
Суудал: Хий

Энэ өдөр гахай жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бар, туулай жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр хууль цааз гаргах, батлах, хэрэглэх, хулгай дээрмийг номхотгох, гэмтнийг шийтгэх, мал адгуус номхруулах, угаал үйлдэх, мал худалдан авах, мал түгээх, огторгуйн үүдийг боох, их хүмүүнтэй уулзахад сайн. Сахил санваар авах, хануур, төөнүүр хийлгэх, балгадын суурь тавих, нохой худалдан авахад муу.

Өдрийн сайн цаг нь бар, туулай, могой, бизар, нохой, гахай болой. Хол газар яваар одогсод урагш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал эрч хүч ихэснэ.





Монгол цэрэг энхийн үйлсэд

"ШИЛДЭГ БОГИНО ХЭМЖЭЭНИЙ БИЧЛЭГ" ШАЛГАРУУЛАХ УРАЛДААНД УРЬЖ БАЙНА



Монгол цэрэг-Энхийн үйлсэд 20 жилийн ойн хүрээнд "Шилдэг богино хэмжээний бичлэг" шалгаруулах уралдаан үргэлжилж байна. Тус уралдаанд оролцож, бүтээлээ ирүүлэхийг хүссэн бүрэлдэхүүнд сонордуулахад, богино хэмжээний бичлэг нь энхийг сахиулах ажиллагааны түүх, үйл ажиллагааны онцлог,

уламжлал шинэчлэлийн утга санаа, онцлох үйл явдлыг бэлгэдсэн утга агуулга бүхий уран сайхны бүтээл байх юм. Түүнчлэн ямар ч төрлийн видео хийх программ, аппликейшн ашиглаж болох бөгөөд бичлэгт орж буй зураг, бичлэг дуу дүрсний өндөр нягтаршилтай байх, HD форматтай байх, бичлэгийн үргэлжлэх хугацаа 2-3 мин

байх, бичлэгт ашиглагдаж буй дуу, дүрс нь зохиогчийн эрхийн зөрчилгүй байх гэсэн шаардлагуудыг хангах хэрэгтэй. Бүтээлийг Монгол цэрэг-Энхийн үйлсэд 20 жил page хуудсаар болон psod.auttoc@gmail.com и-мэйл хаягаар 2022 оны 2 дугаар сарын 25-ны дотор хүлээн авна.

2022 ОНЫ 02 ДУГААР САРЫН 10 ӨДРӨӨС "ӨДРИЙН ЭМЧИЛГЭЭ" НЭЭГДЛЭЭ

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

ӨДРИЙН ЭМЧИЛГЭЭ НЭЭГДЛЭЭ

ӨДРИЙН ЭМЧИЛГЭЭНД ХЭРХЭН ХАМРАГДАХ ВЭ?

1. Цахим бүртгэлээс цаг авах;
2. Эмчид үзүүлэх;
3. Шинжилгээнд хамрагдаж эмчлүүлэх шийдвэр гарах;
4. Цахим бүртгэлд өвчний түүх нээлгэх;
5. ПСР шинжилгээ өгөөд хариу "СӨРӨГ" гарсан байх;
6. Өдрийн эмчилгээний эмчид үзүүлж эмчилгээ эхэлнэ.

Эрцл мэндийн даатгал төлдөг иргэд үйлчлүүлнэ.



Цахим шууданд

ЦЭРГИЙН АЛБА ХААГЧДАА ЭРГЭВ



гарын бэлэг гардуулав. Хүрэлцэн ирсэн зочид төлөөлөгчид хугацаат цэргийн алба хаагчдын бэлтгэсэн урлагийн хэсэгчилсэн тоглолтыг үзэж, өдөр тутмын сургалт, бэлтгэлтэй танилцсан юм. Энэхүү үйл ажиллагаа нь ар гэрээсээ хол алба хааж буй цэргүүдэд урам өгсөн сайхан ажил болж өндөрлөлөө.

Дэслэгч Г.НАНДИНЧИМЭГ

Зэвсэгт хүчний 167 дугаар анги

Өмнөговь аймгийн Засаг дарга Р.Сэддорж, ангийн захирагч хурандаа Ж.Амаржаргал, цэргийн штабын дарга хурандаа Д.Эрдэнэбаяр нар Өмнөговь, Дундговь, Өвөрхангай, Улаанбаатар хотоос 2021 онд хугацаат цэргийн албанд татагдан ирсэн дайчдад Усан бар жилийн сар шинийн мэндчилгээ дэвшүүлж,



САНХҮҮГИЙН МЭДЛЭГ ОЛГОХ СУРГАЛТ ЯВУУЛЛАА



Зэвсэгт хүчний 017 дугаар анги

Ангийн "Ахлагчийн зөвлөл"-ийн урилгаар Монгол банкны Сургалт судалгааны төвийн мэргэжилтэн эдийн засагч Н.Баттуул хүрэлцэн ирж, "Хувь хүний санхүү, төлөвлөлт" сэдвээр сургалт


зохион байгууллаа.

Энэхүү сургалтын явцад "Хувь хүний санхүү, өрхийн төсвийг хэрхэн зөв зохистой зарцуулах вэ?", "Криптовалют гэж юу вэ?", "Хуримтлалыг хэрхэн үүсгэх вэ?", "Хуримтлал ба өгөөж" зэрэг агуулгын хүрээнд мэдээ мэдээлэл өгөв.

Ийнхүү хувь хүн санхүүгийн сахилга баттай байх, өрхийн төсвийг зөв удирдах арга барилд суралцах чиглэлээр бие бүрэлдэхүүний ойлголт, мэдлэгийг өргөжүүлсэн үр өгөөжтэй сургалт болсон юм.

Тэргүүн ахлагч А.ЦЭРЭНТОГТОХ

АНУ "НЭГ ХЯТАД" ЗАРЧМЫГ ЗӨРЧИЖ БАЙНА



АНУ Тайванд зенит пуужингийн "Патриот" цогцолбор болон түүний дагалдах хэрэгсэл, эд анги нийлүүлж байгаа нь "Нэг Хятад" зарчмыг зөрчиж байгаа үйлдэл

гэж Хятадын ГХЯ-ны хэвлэлийн төлөөлөгч Жао Лижиан мэдэгдэв. АНУ-ын энэхүү үйлдэл нь "Нэг Хятад" бодлогыг ноцтой үгүйсгэж байгаа хэлбэр

бөгөөд Хятадын бүрэн эрх, үндэсний аюулгүй байдлын ашиг сонирхолд ноцтой хохирол учруулсан явдал болохыг Хятад улс эрс эсэргүүцэн буруушааж байна. Ийм учир Хятад улсын зүгээс АНУ-ыг "Нэг Хятад" бодлогыг дэмждэг гэдгээ нотолж, Тайваниас цэргийн харилцаа болон зэвсгийн наймааны гэрээндээ цуцлахыг уриалж байна. Хятад улс нь өөрийн бүрэн эрх, газар нутгийн аюулгүй байдал үндэсний ашиг сонирхлоо тууштай хамгаалахын тулд "хууль ёсны бөгөөд үр дүнтэй арга хэмжээ авна" гэж мэдэгдэв.